

**Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны
ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
Төслийн зорилго:	3
Төслийн дэд бүтэц.	3
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТГИЙН ФИЗИК ГАЗАРЗҮЙ.....	3
Гадаргын болон газрын гүний ус.	4
Уур амьсгал	5
Ургамал, амьтны аймаг	5
ГУРАВ. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	5
Агаарын чанар.....	5
Хөрсөн бүрхэвч.....	5
Ургамлан нөмрөг.....	6
Амьтны аймаг.....	6
Гадаргын болон газрын доорх ус	6
Нийгэм эдийн засаг.....	6
ДӨРӨВ. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	7
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.	7
4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	13
4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт ..	13
4.4. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	15
4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15
4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	15
4.7. Удирдлага зохион байгууллалтын төлөвлөгөөний биелэлт	25
4.8. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах	29
ТАВ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	30
I. Хөрсний шинжилгээ	31
II. Агаарын чанарын шинжилгээ	32
III. Усны шинжилгээ	33
ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НИЙТ ТӨСӨВ	34
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	35
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ	35

**Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны
ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.....	3
Хүснэгт 2. Төслийн талбайн солбицол	3

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил.....	4
Зураг 2. Ангилаан ялгах хогийн савны материал, хийц.....	10
зураг 3. Замын тэмдэг тэмдэглэгээ хийсэн ажлын зураг.....	12
Зураг 4. Кемпийн урд хэсэгт мод тарьсан ажлын зураг	14
Зураг 5. Орон нутагт мод хандивлаж буй байдал.	14
Зураг 6. Анхны тусламжийн эм, тариа, багаж хэрэгсэл	17
Зураг 7. Кемпийн гадна байрлуулсан галын сараа.	18
Зураг 8. Шатхуун түгээх станцын дэргэд болон харуулын байрны гаднах галын сараа.	19
Зураг 9. Сууц болон гэрүүдэд байрлуулсан галын хорууд.	20
Зураг 10. Галын аюул, эрсдэлээс сэргийлэх тухай сургалт	22
Зураг 11. Ажилчдыг ажлын хувцсаар хангасан байдал.	28

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сэрвэн хайлуур жоншны ордод 2007 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлангаар бодитой (В) зэрэглэлээр 46.68%-ийн дундаж агуулгатай 370.3 мян.тн хүдрийн нөөц тогтоогдож Монгол улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

Төслийн зорилго: “Сэрвэнгийн хайлуур жоншны ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт учруулах сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг авч, илэрсэн зөрчлийг арилгах, холбогдох хууль журмын хэрэгжилтийг хангах, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах, ажилчдыг аюулгүй тав тухтай орчинд ажиллах нөхцөл бололцоогоор хангаж ажиллана.

Хүснэгт 1.

Төслийн нэр	“Сэрвэн” хайлуур жоншны ордыг ашиглах төсөл
Төсөл хэрэгжүүлэгч	“Чинг Хиен Вей Еэ” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011652061
Регистрийн дугаар	6191142
ААН-ийн хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо 45А байр, 302 тоот

Төслийн дэд бүтэц.

Усан хангамж. Унд ахуйн хэрэглээнд ашиглах усны хэрэгцээг төсөл хэрэгжих талбайд байрлах гүний худгаас, зам талбайн тоосжилт дарах болон нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн усалгаанд шаардлагатай усны хэрэгцээг уурхайн үйл ажиллагааны явцад шүүрэн орж ирэх шүүрлийн усаар хангана.

Усны төлбөрийг Хэрлэн голын сав газрын захиргаатай байгуулсан 2024 оны ус ашиглах гэрээнд зааснаар унд ахуйн худаг болон шүүрлийн ус шавхах хэсэгт суурилуулсан тоолуурын заалтын дагуу төлсөн бөгөөд гэрээний хэрэгжилтэд Батноров сумын ЗДТГ-аас хяналт тавин ажиллаж байна.

Цахилгаан хангамж.

Сэрвэн уурхай нь төвийн эрчим хүчнээс алс зайд оршдог тул уурхайн шаардлагатай эрчим хүчийг Дизель – Станц буюу дизель цахилгаан үүсгэврээр хангаж байна.

БНХАУ-д үйлдвэрлэсэн STF-650-1-4 маркын 630 кВт чадалтай 2 ширхэг дизель генератор сонгосон.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТГИЙН ФИЗИК ГАЗАРЗҮЙ

“Сэрвэн”-ийн хайлуур жоншны орд нь засаг захиргааны хуваарийн дагуу Хэнтий аймгийн Батноров сумын 5-р багийн нутаг дэвсгэрт харьяалагдах бөгөөд Батноров сумын төвөөс зүүн урагш 27 км, Улаанбаатар хотоос зүүн тийш 237 км, Бэрх тосгоноос хотоос зүүн урагш 33 км зайд тус тус оршино.


Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь физик газарзүйн хувьд Төв азийн их муж, Монголын дорнод мужийн Улз Хэрлэнгийн дэд мужид багтдаг, далайн түвшнээс дээш 1000-1500 м өргөгдсөн.

Байгалийн бүс бүслүүрийн хувьд хуурай хээрийн бүсэд хамаарна.

Хүснэгт 2. Төслийн талбайн солбицол

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Уртраг	Өргөрөг
1.	111° 35' 35.98"	47° 42' 9.77"
2.	111° 35' 11.98"	47° 42' 9.77"
3.	111° 35' 11.98"	47° 42' 36.77"
4.	111° 35' 35.98"	47° 42' 36.77"



Зураг 1. Төслийн талбайн байршил

Гадаргын болон газрын гүний ус.

“Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн талбай нь Монгол орны усны сав газрын ангиллаар Хэрлэн голын сав газарт харьяалагдах бөгөөд усны тухай хуульд заасны дагуу тухайн жилийн ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт болон ус ашиглах гэрээг тус сав газрын захиргаатай байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хэрлэн голын сав газар нь Монгол орны зүүн хэсэгт, эдийн засгийн Төв, Зүүн бүсэд, Говьсүмбэр, Дорнод, Дорноговь, Хэнтий, Төв, Сүхбаатар зэрэг хэд хэдэн аймгийн нутгийг дамнан оршино.

Төсөл хэрэгжих талбайн орчимд гадаргын ус байхгүй бөгөөд төслийн үйл ажиллагаанд шаардагдах усны хэрэгцээг газрын гүний усаар хангана.

Хэрлэн голын сав газарт газрын доорх ус нь ихэнхдээ эрдэсжилт, хатуулаг багатай цэнгэг найрлагатай байдаг. Хэрлэн голын сав газрын эхэн хэсэгт 43 сая м³ /жил, дунд хэсэгт 621 сая м³ /жил, адаг хэсэгт 57 сая м³ /жил ашиглалтын баримжаат газрын доорх усны нөөц тус тус тархсан байна. [5]

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Уур амьсгал

Хэнтий аймгийн Батноров сумын нутаг дэвсгэр нь уур амьсгалын хувьд чийглэгдүү ширүүн мужид хамаарагдах бөгөөд жилд унах хур тунадасны хэмжээ 200-300 мм.

Жилд орох хур тунадасны дийлэнх хувь нь дулаан улиралд буюу 4-9 дүгээр сарын хооронд орно.

Агаарын температурын дундаж хэмжээ өвлийн сард -20.6°C , зуны сард $+19.4^{\circ}\text{C}$, жилийн дундаж салхины хурд 3-4 м/с.

Ургамал, амьтны аймаг

Хэнтий аймгийн Батноров сумын нутаг дэвсгэрт хамаарч байгаа бөгөөд энэ хэсгийн район нь ургамал газарзүйн мужлалаар Дундад халхын хуурай хээрийн тойрогт багтана. Энэ тойрогт Хангайн нуруунаас зүүн тийш, Төв Монголын боржин чулуутай цохио, толгод, бэсрэг уулс бүхий ухаа гүвээрхэг тэгшивтэр нутгууд хамаарна. Тойргийн хэмжээнд нийт 791 зүйлтэй бөгөөд ургамлын аймгийн хувьд биеэ даасан өвөрмөц онцлог багатай, хэд хэдэн тойргийн шилжих зааг дээр байрлах тул Төв Азийн Монгол хошуу болоод Дагуурын хээрийн, зарим нь цөлөрхөг хээрийн, бас умардын уулсын элементүүд ч оролцоно (*Монгол орны гуурст ургамлын тархалтын өнөөгийн төлөв байдал. М.Ургамал, Ж.Магсар, 2017 он.*).

Батноров сумын нутгийн хойд уулархаг хэсгээр хус, бургас, улиас, яргай, хайлаас, гацуур гэх мэт жижиг ой төгөлтэй, нохойн хошуу, дэгд, тарваган шийр, цөс өвс, таван салаа, сөд, бамбайн үндэс зэрэг эмийн ургамал, уулын хээрийн хярганы хиагт, үетэй хялганат, шивээт хялгана, түнхлээ, хиаг, саман ерхөг, цэцэгт дааган сүүл гэх мэт бэлчээрийн ургамлууд зонхилно.

Амьтны аймаг. Батноров сумын нутагт монгол тарвага, бор гөрөөс, цагаан зээр, саарал чоно, үнэг, хярс, шилүүс, мануул, дорго, туулай, чандага, өмхий хүрэн, зурам зэрэг амьтад элбэг тохиолдоно.

Монгол орны шувуудын зүйлээс тус нутагт тогоруу, хун, галуу, нугас, ангир зэрэг усны шувууд, шар шувуу, шонхор, тас, сар, хур сойр, ятуу, болжмор, хэрээ, хараацай шувууд нутагладаг байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Агаарын чанар

- ⇒ Бүтээгдэхүүн тээвэрлэх үеийн машины утаа тортог, замын тоос үүсэх
- ⇒ Хүдэр боловсруулах үед үүсэх тоосжилт
- ⇒ Барилга байгууламжийн орчмын шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх
- ⇒ Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

Хөрсөн бүрхэвч

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- ⇒ Барилга байгууламжийн ойр орчмын шимт хөрс элэгдэж, эвдэрснээс ургамлан нөмрөг талхлагдах

**Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны
ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

- ⇒ Ачиж тээвэрлэх үеийн машин техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх
- ⇒ Олон салаа зам гарган зорчих
- ⇒ Машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох
- ⇒ Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- ⇒ Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

Ургамлан нөмрөг. Хүнд машин техникийн хөдөлгөөн, замын тогтсон маршрутгүйгээр зорчих, анхаарал болгоомжгүйгээс гал түймэр гарах, хог хаягдлыг ил задгай хаях зэрэг нь тухайн орчмын ургамлан нөмрөг устгах, түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (хог ургамал ихсэх) сөрөг нөлөө учруулна.

Амьтны аймаг.

Төслөөс амьтны аймагт нөлөөлөх шууд нөлөөлөл байхгүй. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн орчимд тээврийн хэрэгсэл, техникийн дуу чимээний нөлөөнөөс ойр орчмын амьтад дайжиж, амьдрах орчин хумигдсан.

Гадаргын болон газрын доорх ус

- ⇒ Уурхайн үйл ажиллагаанд шаардагдах усны хэрэглээг гүний худгаас хангах тул тухайн бүсийн газрын доорх усны нөөцөд нөлөөлөх магадлалтай.
- ⇒ Мөн уурхайн олборлолтын явцад үүсэх шүүрлийн усыг шавхах ажил нь тухайн бүс нутгийн гүний уснб нөөцөд нөлөө үзүүлнэ.
- ⇒ Ахуйн бохир ус болон хог хаягдлыг зөв байршуулаагүй мөн орчны цэвэрлэгээ хийгээгүйн улмаас гадаргын болон хөрсний усыг тодорхой хэмжээгээр бохирдуулж болзошгүй.


Нийгэм эдийн засаг

Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмын албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг улс болон орон нутгийн төсвийн санд оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр орон нутагт шинэ ажлын байр нэмэгдэх боломжтой юм.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ДӨРӨВ. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт
Агаар	<p>Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх</p> <p>Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хийж агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийг бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах</p>	<p>Манай “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ашиглах уурхайд одоогоор нийт 7 машин техник ашиглаж байгаа бөгөөд тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлын үзлэг, шалгалтыг тогтмол хийж ажилладаг. Уурхайд тоосжилт харьцангуй бага үүсдэг.</p>  <p align="center">■ SO4 ■ NO2 ■ нийт тоос</p> <p align="center">КАРЬЕР КЕМП ШТС ХҮЛЦЭХ АГУУЛАМЖ</p> <p>Уурхайн орчимд хийсэн агаарын бохирдлын шинжилгээний дүнг Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартад заасан агаар дахь бохирдуулагч бодисын хүлцэх агууламжтай харьцуулж үзэхэд давсан үзүүлэлт байгаагүй. /Агаарын чанарын шинжилгээний дүн, улсын эрүүл ахуйн байцаагчийн дүгнэлтийг хавсралт материалд хавсаргав./</p> <p>Мөн уурхайн орчмын тоосжилтыг хянаж байх зорилгоор агаарын тоосжилт хэмждэг багаж авсан байгаа бөгөөд цаашид өдөр тутамдаа агаарын тоосжилтын хэмжилт хийж шаардлагатай тохиолдолд замын усалгаа хийнэ.</p>
	Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх	2024 оны ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах гэрээг Хэрлэн голын сав газрын захиргаатай байгуулж ус ашигласны төлбөрийг уурхайн унд ахуйн гүний худаг болон шүүрлийн ус соруулах хэсэгт суурилуулсан тоолуурын заалтын дагуу төлсөн.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

	<p>Ундны усны цооногоос шинжилгээ хийлгэх</p>	<p>/Ус ашиглуулах дүгнэлт, усны гэрээ болон төлбөр төлсөн баримтыг хавсралт материалд хавсаргав./</p> <p>Уурхайн унд ахуйн зориулалтаар ашиглаж байгаа гүний худгийн уснаас шинжилгээ хийлгэсэн бөгөөд усанд агуулагдах химийн элементүүд Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018 стандартад заасан хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна.</p> <table border="1"> <thead> <tr> <th>Химийн элемент</th> <th>Ундны ус</th> <th>Хүлцэх агууламж</th> </tr> </thead> <tbody> <tr><td>CA2+</td><td>41.7</td><td>30</td></tr> <tr><td>MG2+</td><td>100</td><td>0.79</td></tr> <tr><td>NH4+</td><td>7.49</td><td>1.5</td></tr> <tr><td>FE</td><td>0.79</td><td>0.05</td></tr> <tr><td>CI-</td><td>1.5</td><td>350</td></tr> <tr><td>SO42-</td><td>0.05</td><td>500</td></tr> <tr><td>NO2</td><td>0.3</td><td>0.002</td></tr> <tr><td>NO3</td><td>9.6</td><td>1</td></tr> <tr><td>PO43-</td><td>19.3</td><td>2.26</td></tr> <tr><td>F-</td><td>0.002</td><td>50</td></tr> </tbody> </table> <p>/Шинжилгээний дүн болон улсын эрүүл ахуйн байцаагчаар гаргуулсан дүгнэлтийг хавсаргав./</p>	Химийн элемент	Ундны ус	Хүлцэх агууламж	CA2+	41.7	30	MG2+	100	0.79	NH4+	7.49	1.5	FE	0.79	0.05	CI-	1.5	350	SO42-	0.05	500	NO2	0.3	0.002	NO3	9.6	1	PO43-	19.3	2.26	F-	0.002	50
Химийн элемент	Ундны ус	Хүлцэх агууламж																																	
CA2+	41.7	30																																	
MG2+	100	0.79																																	
NH4+	7.49	1.5																																	
FE	0.79	0.05																																	
CI-	1.5	350																																	
SO42-	0.05	500																																	
NO2	0.3	0.002																																	
NO3	9.6	1																																	
PO43-	19.3	2.26																																	
F-	0.002	50																																	
<p>Уст цэг болон булаг шандын эхийг цэвэрлэх</p>		<p>Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд уст цэг байхгүй, талбайн ойр орчимд булаг шанд байдаггүй. Хэрлэн голын ай сав дагуух малын сэг зэмийг ковшоор цэвэрлэсэн. /Ажлын зургийг хавсралт материалд хавсаргав./</p>																																	
<p>Хөрсөн бүрхэвч</p>	<p>Уурхайн орчны замын дагуу стандартын тэмдэгжүүлэх ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлэх</p>	<p>Уурхайн дотоод тээврийн зам дагуу дараах тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Дотоод замд хурдны хязгаарыг тогтоож 40 км/ц-аас хэтрэхгүй байхыг сануулсан тэмдэг, - Уурхайд дотоод замын дагуу огцом уруудаж, өгсөж байгаа хэсэгт эгц уруу болон огцом өгсүүр гэсэн тэмдэглэгээ, - Орохыг хориглох тэмдгүүдийг тус тус байрлуулсан бөгөөд цаашид шаардлагатай тэмдэг тэмдэглэгээг нэмж байрлуулна. (Зураг.3) 																																	

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Хавсралт материалд сургалтын удирдамж болон сургалт зохион байгуулсан ажлын зургийг хавсаргав.
	Автомашинны хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах тэмдэг тавих	Уурхайн дотоод тээврийн замаар 40км/ц-аас хэтрэхгүй зорчихоор хурдны хязгаар тогтоож, тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан. Уурхайн нийт ажилчдад олон салаа зам гаргахгүй байх талаар сургалт зохион байгуулсан. /Сургалтын удирдамжийг хавсралт материалд хавсаргав./
	Шаардлагагүй газар ухаж сэндийчихгүй байх.	Уурхайн ашиглалтын талбайгаас гадна хэсэгт ямар нэг байдлаар газар хөндөх ажил хийгээгүй болно.
	Төслийн талбайд ангилан ялгах тасалгаатай хогийн сав байрлуулж сард 1 удаа төвлөрсөн цэгт хаях	Ажилчдын ахуйн хэрэглээнээс үүсэх хог хаягдлыг дараах гурван төрлөөр ангилан хаях зориулалттай төмөр хогийн савыг ажилчдын кемпийн гадна хэсэгт байрлуулсан.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2. Ангилан ялгах хогийн савны материал, хийц

Батноров сумын ЗДТГ-тай байгуулсан 2024 оны энгийн хог хаягдлын гэрээний дагуу үүссэн хог хаягдлыг сард нэг удаа уурхайн өөрийн зардлаар сумын хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэдэг.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



зураг 3. Замын тэмдэг тэмдэглэгээ хийсэн ажлын зураг.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

- 2024 онд ТЭЗҮ болон 2024 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгасаны дагуу техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.

4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт

Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт
“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” хөтөлбөрийн хүрээнд төслийн талбайн ойр орчим мод тарих	<p>Тус ажлын хүрээнд нийт 550 ширхэг улиас модны суулгац худалдан авч 100 ширхэг суулгацыг орон нутагт хандивлан үлдсэн 450 ширхэг суулгацыг уурхайн кемпийн урд хэсэгт 0.5 га талбайд тарьсан. (Зураг.4,5)</p> <p>Улиас модны суулгацыг тарихдаа:</p> <ol style="list-style-type: none"> 1. 60 см гүнтэй, 70 см диаметртэй, суулгац хоорондын зайг 3 м байхаар нүх ухсан, 2. Суулгацаа тарихдаа нүхийг голлуулан үндсийг нугалахгүйгээр жигд тараан суулгасан, 3. Суулгасны дараа ухсан хөрсөөрөө хучиж, хөрсийг нягтаршуулан гишгэж өгсөн. 4. Модны усалгааг хийхдээ нэг суулгацыг ойролцоогоор 40-50 л усаар усалсан бөгөөд нийт дөрвөн сарын хугацаанд долоо хоногт хоёр удаа усалгаа хийсэн.



Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 4. Кемпийн урд хэсэгт мод тарьсан ажлын зураг



Зураг 5. Орон нутагт мод хандивлаж буй байдал.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

4.4. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

- Тухайн жилд төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

- Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт
Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, машин техникийн үйлчилгээ засварыг тогтмол явуулж хэвших	Уурхайд ашиглаж байгаа машин механизмуудын 90 гаруй хувь түрээсийн техникүүд байдаг бөгөөд түрээсийн гэрээнд заасны дагуу түрээслэгч нь машин техникийн бүрэн бүтэн байдал, засвар үйлчилгээг хариуцаж ажилладаг. /Түрээсийн гэрээг хавсралт материалд хавсаргав./
Төслийн талбайд болзошгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах.	Төслийн талбайд барилга байгууламж бүрт галын хор байрлуулж, галын сарааг ШТС, харуулын байр, кемпийн гадна тохижуулсан. (Зураг.7, 8, 9)
Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Уурхайн нийт ажилчдад галын болон байгалийн аюул гамшгаас сэргийлэх тухай сургалтыг зохион байгуулсан. (Зураг.10)
Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн багаж хэрэгсэл байрлуулах.	Уурхайн ажилчдын кемпэд анхан шатны эмийн сантай бөгөөд эм тарианы хангамж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдалд уурхайн эмч хяналт тавьж ажилладаг. (Зураг.6) Анхны тусламжийн эмийн санд: 1.Витамин С, Д 2. Халуун бууруулах эм 3. Өвчин намдаах эм

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

	<p>4.Хамрын дусаалга 5. Харшлын эм 6.Гэдэсний эм 7. Шархны тос 8. Даралт бууруулах эм/эмчийн заалтаар/ 9. Вазелин 10.Гуурсан хоолой тэлэх эм /эмчийн заалтаар/ 11. Шингэн сэлбэх давсны уусмал /хросол/ 12.Бөөлжилт,дотор муухай оргилтыг намдаах /нүүрсэн эм/ Эмийн бус зүйл: 1.Пульсоксиметр 2.Даралтны аппарат 3.Халууны шил 4.Ариутгалын уусмал/спирт,иод,тамедин/ 5.Самбай,Хөвөн 6.Бинт,Шархны тос 7. Жижиг хайч 8.Нэг удаагийн бээлий 9.Жин тавих зүйл</p>
<p>Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тогтмол хийх</p>	<p>Уурхайд ашиглаж байгаа машин механизмуудын 90 гаруй хувь түрээсийн техникүүд байдаг бөгөөд түрээсийн гэрээнд заасны дагуу түрээслэгч нь машин техникийн бүрэн бүтэн байдал, засвар үйлчилгээг хариуцаж ажилладаг. /Түрээсийн гэрээг хавсралт материалд хавсаргав./</p>

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 6. Анхны тусламжийн эм, тариа, багаж хэрэгсэл

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 7. Кемпийн гадна байрлуулсан галын сараа.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 8. Шатхуун түгээх станцын дэргэд болон харуулын байрны гаднах галын сараа.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 9. Сууц болон гэрүүдэд байрлуулсан галын хорууд.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 10. Галын аюул, эрсдэлээс сэргийлэх тухай сургалт

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Байгууллагын нэр *Сэрвэн, Гурми* Цех, тасаг, нэгжийн нэр
 Машины марк *Х.В.С.1* Машины дугаар Жолоочийн нэр *Батсүрэн, Дэлгэц, Байршигдари*

№	Он сар өдөр	Явсан хүний		Засвар	мото/цаг	мотор тос	Спилометрийн			Бензин		Масло		Гарын үсэг
		Албан тушаал	Нэр				гидер-н шин	хроп шин	тормоз шин	Норм	Зарсан	Норм	Зарсан	
10/1	Молгол	Байршигдари	Мотор эвний	✓	✓				✓					Байршигдари
			<i>сольсон, бүрт үйлчилгээ хийсэн.</i>											
10/2	Молгол	Байршигдари	Вибраци			✓		✓	✓					Байршигдари
			<i>цэр амст галнаб.</i>											
10/13	Молгол	Байршигдари	Бичигд			✓		✓	✓					Байршигдари
			<i>шилэ мат-дүргэлч гална</i>			✓		✓	×					
10/22	Молгол	Байршигдари	Машиний											Байршигдари
			<i>решет сольсон</i>			✓		✓	✓					
10/22	Молгол	Байршигдари	Ремонт, Мотор											Байршигдари
		Дүн	<i>ийсрсэн</i>			✓		✓	✓					

Тооцоо бодсон нягтлан бодогч
 Тооцоо бодуулсан жолооч
 Мс хялж : Зондаев.

Зураг 11. Машин техникийн засвар үйлчилгээ хийсэн бүртгэл, Хово

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

4.7. Удирдлага зохион байгууллалтын төлөвлөгөөний биелэлт

Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт
Ажилчдад байгаль орчныг хамгаалах талаар сургалт зохион байгуулах	Уурхайн нийт ажилчдад байгаль орчин хамгаалах болон хог хаягдлыг ангилан ялгах тухай сургалтыг зохион байгуулсан. (Зураг.11.)
Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн журмыг ажилчдад мөрдүүлэн ажиллах.	Уурхайн хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн дотоод журмыг боловруулан ажилчдад мөрдүүлж ажиллаж байна. /Хавсралт материалд хавсаргав./
Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Уурхайн нийт ажилчдыг зориулалтын ажлын хувцсаар ханган ажиллаж байна. (Зураг.12)
Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	Сэрвэн уурхай нь 2024 оны 11-р сараас эхлэн мэргэжлийн эмчтэй болсон бөгөөд өмнөх саруудад худалдан авсан эм тарианы бүртгэл хийгдээгүй байна. 11-р сард анхны тусламжийн шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд нийт 184,500 төгрөг зарцуулсан байна. /Эм, тариа, багаж хэрэгсэлд шаардагдсан зардлын баримтыг хавсралт материалд хавсаргав./

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 13. Байгаль орчин хамгаалах тухай сургалт

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 14. Ажилчдыг ажлын хувцсаар хангасан байдал.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

4.8. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах

БОМТ түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэрүүд	Мэдээний агуулга	Хэлэлцүүлгээр санал авах	Биелэлт
Бомт-ийн биелэлтийг оршин суугчдад тайлагнах				
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Хэнтий аймгийн Батноров сумын засаг захиргааны байгууллагад танилцуулж, хэлэлцүүлнэ.	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумдын засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	Сумын засаг захиргааны удирдлага болон байгаль орчны байгууллагын санал, шүүмжийг хүлээн авч шийдвэрлэх	Батноров сумын 5-р багийн ИНХ-ын тов одоогоор гараагүй байгаа бөгөөд хуралд оролцох хүсэлтийг багийн даргад хүргүүлсэн.
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Хэнтий аймгийн Батноров сумын нутгийн оршин суугчдад танилцуулж хэлэлцүүлнэ.	Нутгийн оршин суугчдад БОМТ-ний биелэлтийг тайлагнах	БОМТ-ний биелэлт	Оршин суугчдын санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	Батноров сумын 5-р багийн ИНХ-ын тов одоогоор гараагүй байгаа бөгөөд хуралд оролцох хүсэлтийг ЗДТГ-т болон багийн засаг даргад хүсэлт өгсөн. Хурлын тов гарсан тохиолдолд багийн иргэдэд танилцуулна.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ТАВ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, орчны төлөв байдалд үзүүлж буй өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянахад Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр ач холбогдолтой байна.

Сэрвэнгийн хайлуур жоншны ордыг ашиглах төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Хэнтий аймгийн УЦУОШГазартай хамтран агаарын тоосжилт болон бохирдуулагч хийн агуулгыг тодорхойлох шинжилгээг уурхайн карьер, кемпийн гадна хэсэг, ШТС-ын дэргэдээс, хөрсний агрохимийн шинжилгээг уурхайн авто зогсоол, кемпийн гадна хөрс болон шимт хөрсний овоолгоос, усны чанарын шинжилгээг шүүрлийн ус болон унд ахуйн уснаас тус тус дээж аван Хэнтий аймгийн УЦУОШТ, Байгаль орчны лабораторид шижлүүлсэн.

Шинжилгээний хариунд Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуйн улсын байцаагчаар дүгнэлт гаргуулсан.

Цаашид шинжилгээ хийх давтамжийг нэмэгдүүлэн жилд 2-оос дээш удаа хөрс, ус, агаарын шинжилгээ хийж байхаар төлөвлөгөөнд тусгах бөгөөд шинжилгээний хариунд боловсруулалт хийн учруулж буй сөрөг нөлөөллийг багасгах бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллана.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

I. Хөрсний шинжилгээ



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ

Хэнтий аймаг Харгэн сум 2-р баг тэмүүжингийн
гудамж Н-13
Утас/Факс: 93028611, 96092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com



Сорьцны дугаар: 44
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: “Чинг хен вэй өз” ХХК авто зогсоол
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-н инженер Б.Шүрэнчимэг
Сорьцны тоо, хэмжээ: 800гр
Сорьцны төрөл: Хөрс
Сорьц авсан огноо: 2024.08.28
Лабораторид хүлээж авсан : 2024-08-30
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024-08-30
Хэвлэсэн огноо: 2024-10-14
Хуудасны тоо: 1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж		Хүлээх агууламж	Үр дүн
MNS3310:1991	Орчин- рН	-	6.05
MNS3310:1991	Чийг - %	-	%
MNS3310:1991	Ялзмаг	-	7.39
MNS3310:1991	Аммиак- NH ₄ мг / л	-	27.74
MNS3310:1991	Нитрат – NO ₃ мг / л	-	56.03
MNS3310:1991	Сульфат- SO ₄ мг / л	-	290.93
MNS3310:1991	Фосфор (P2 O5) мг / л	-	14.37

ХЯНАЖ БАТААГААЖУУЛСАН
БОШЛ-Н ЭРХЛЭГЧ ИНЖЕНЕР: /Б.ГАНГАНБАЙГАЛ /

БОШЛ-Н ИНЖЕНЕР: ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
ИТГЭМЖЛЭГДСЭН
ЛАБОРАТОРИ
/Б.ШҮРЭНЧИМЭГ /



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ

Хэнтий аймаг Харгэн сум 2-р баг тэмүүжингийн
гудамж Н-13
Утас/Факс: 93028611, 96092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com



Сорьцны дугаар: 45
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: “Чинг хен вэй өз” ХХК намт
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-н инженер Б.Шүрэнчимэг
Сорьцны тоо, хэмжээ: 800гр
Сорьцны төрөл: Хөрс
Сорьц авсан огноо: 2024.08.28
Лабораторид хүлээж авсан : 2024-08-30
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024-08-30
Хэвлэсэн огноо: 2024-10-14
Хуудасны тоо: 1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН


Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж		Хүлээх агууламж	Үр дүн
MNS3310:1991	Орчин- рН	-	8.01
MNS3310:1991	Чийг - %	-	%
MNS3310:1991	Ялзмаг	-	2.80
MNS3310:1991	Аммиак- NH ₄ мг / л	-	0.78
MNS3310:1991	Нитрат – NO ₃ мг / л	-	5.46
MNS3310:1991	Сульфат- SO ₄ мг / л	-	188.89
MNS3310:1991	Фосфор (P2 O5) мг / л	-	0.39

ХЯНАЖ БАТААГААЖУУЛСАН
БОШЛ-Н ЭРХЛЭГЧ ИНЖЕНЕР: /Б.ГАНГАНБАЙГАЛ /

БОШЛ-Н ИНЖЕНЕР: ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
ИТГЭМЖЛЭГДСЭН
ЛАБОРАТОРИ
/Б.ШҮРЭНЧИМЭГ /




Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ

Хэнтий аймаг Харгэн сум 2-р баг тэмүүжингийн
гудамж Н-13
Утас/Факс: 93028611, 96092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com




Сорьцны дугаар: 47
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: “Чинг хен вэй өз” ХХК хяналтын хөрс
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-н инженер Б.Шүрэнчимэг
Сорьцны тоо, хэмжээ: 800гр
Сорьцны төрөл: Хөрс
Сорьц авсан огноо: 2024.08.28
Лабораторид хүлээж авсан : 2024-08-30
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024-08-30
Хэвлэсэн огноо: 2024-10-14
Хуудасны тоо: 1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж		Хүлээх агууламж	Үр дүн
MNS3310:1991	Орчин- рН	-	6.70
MNS3310:1991	Чийг - %	-	%
MNS3310:1991	Ялзмаг	-	11.64
MNS3310:1991	Аммиак- NH ₄ мг / л	-	6.32
MNS3310:1991	Нитрат – NO ₃ мг / л	-	12.56
MNS3310:1991	Сульфат- SO ₄ мг / л	-	137.40
MNS3310:1991	Фосфор (P2 O5) мг / л	-	3.16

ХЯНАЖ БАТААГААЖУУЛСАН
БОШЛ-Н ЭРХЛЭГЧ ИНЖЕНЕР: /Б.ГАНГАНБАЙГАЛ /

БОШЛ-Н ИНЖЕНЕР: ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
ИТГЭМЖЛЭГДСЭН
ЛАБОРАТОРИ
/Б.ШҮРЭНЧИМЭГ /



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

II. Агаарын чанарын шинжилгээ



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ

Хэнтий аймаг Харлан сум 2-р баг тэмүүжингийн
гудамж Н-13
Утас/Факс: 93028611, 98092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com



Сорьцын дугаар: 54
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: “Чинг хөн вэй өз” ХХК харьёр
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-н инженер Б.Шүрэнчимэг
Сорьцын тоо, хэмжээ:
Сорьцын төрөл: Агаар, тоос
Сорьц авсан огноо: 2024-08-28
Лабораторид хүлээж авсан: 2024-08-30
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024-08-30
Хэвлэсэн огноо: 2024-10-14
Хуудасны тоо: 1/1
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Үр дүн	
MNS 17.2.5. 12:88	Хүхэрлэг хий – SO ₂ , мг/м ³	0,450	0,013
MNS 17.2.5. 12:88	Азотын давхар исэл – NO ₂ , мг/м ³	0,200	0,046
CA3 A03	Тоос-нийт, мг/м ³	0,150	0,057

ХЯНАЖ БАТАЛГААЖУУДСАН:
БОШЛ-Н ЭРХЛЭГЧ ИНЖЕНЕР: /Б.ГАНГАНБАЙГАЛ /
ШИНЖИЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН
БОШЛ-Н ТЕХНИКЧ: Н.Тайван /

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ

Хэнтий аймаг Харлан сум 2-р баг тэмүүжингийн
гудамж Н-13
Утас/Факс: 93028611, 98092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com



Сорьцын дугаар: 52
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: “Чинг хөн вэй өз” ХХК кемп
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-н инженер Б.Шүрэнчимэг
Сорьцын тоо, хэмжээ:
Сорьцын төрөл: Агаар, тоос
Сорьц авсан огноо: 2024-08-28
Лабораторид хүлээж авсан: 2024-08-30
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024-08-30
Хэвлэсэн огноо: 2024-10-14
Хуудасны тоо: 1/1
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Үр дүн	
MNS 17.2.5. 12:88	Хүхэрлэг хий – SO ₂ , мг/м ³	0,450	0,047
MNS 17.2.5. 12:88	Азотын давхар исэл – NO ₂ , мг/м ³	0,200	0,063
CA3 A03	Тоос-нийт, мг/м ³	0,150	0,060

ХЯНАЖ БАТАЛГААЖУУДСАН:
БОШЛ-Н ЭРХЛЭГЧ ИНЖЕНЕР: /Б.ГАНГАНБАЙГАЛ /
ШИНЖИЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН
БОШЛ-Н ТЕХНИКЧ: Н.Тайван /

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ

Хэнтий аймаг Харлан сум 2-р баг тэмүүжингийн
гудамж Н-13
Утас/Факс: 93028611, 98092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com



Сорьцын дугаар: 53
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: “Чинг хөн вэй өз” ХХК ШТС
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-н инженер Б.Шүрэнчимэг
Сорьцын тоо, хэмжээ:
Сорьцын төрөл: Агаар, тоос
Сорьц авсан огноо: 2024-08-28
Лабораторид хүлээж авсан: 2024-08-30
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024-08-30
Хэвлэсэн огноо: 2024-10-14
Хуудасны тоо: 1/1
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН


Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Үр дүн	
MNS 17.2.5. 12:88	Хүхэрлэг хий – SO ₂ , мг/м ³	0,450	0,021
MNS 17.2.5. 12:88	Азотын давхар исэл – NO ₂ , мг/м ³	0,200	0,025
CA3 A03	Тоос-нийт, мг/м ³	0,150	0,011

ХЯНАЖ БАТАЛГААЖУУДСАН:
БОШЛ-Н ЭРХЛЭГЧ ИНЖЕНЕР: /Б.ГАНГАНБАЙГАЛ /
ШИНЖИЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН
БОШЛ-Н ТЕХНИКЧ: Н.Тайван /

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.


Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан


III. Усны шинжилгээ



**УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ**


Хэнтий аймаг Хэрлэн сум 2-р баг тэмүүжингийн
гудамж Н-13
Утас/Факс: 93028611, 98092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com





**УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ**

Хэнтий аймаг Хэрлэн сум 2-р баг тэмүүжингийн
гудамж Н-13
Утас/Факс: 93028611, 98092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com



Сорьцын дугаар: 39
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: “Чинг хөн вэй өз” ХХК ундны ус
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-н инженер Б.Шүрэнчимэг
Сорьцын тоо, хэмжээ: 1,5литр
Сорьцын төрөл: Ус
Сорьц авсан огноо: 2024-08.28
Лабораторид хүлээж авсан : 2024-08-30
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024-08-30
Хэвлэсэн огноо: 2024-10-14
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Тодорхойлсон үзүүлэлт Шинжилгээний арга стандарт	Сорьц авсан цэг “ Чинг хөн вэй өз” ХХК /хүдгийн ус/	MNS 0900:2018 Хүлцэх агууламж мг/л	
		Хүлцэх агууламж мг/л	Хүлцэх агууламж мг/л
Жинлэгдэх бодис /MNS 6836:2020/	Ж/Б мг/л	26.4	-
Перманганатын исэлдэх чанар /MNS 6833:2020/	Пич мг/л	1.26	-
Кальцийн ион /MNS ISO 1097:1970/	Ca ²⁺ мг/л	41.7	100.0
Магний ион /MNS ISO 1097:1970/	Mg ²⁺ мг/л	7.49	30.0
Аммоний ион /CA3 1:2020/	NH ₄ ⁺ мг/л	0.79	1.5
Нийт төмөр /MNS 4430:2005/	Fe мг/л	0.05	0.3
Хлорийн ион /MNS 4424:2005/	Cl ⁻ мг/л	9.6	350
Сульфатын ион /MNS 6271:2011/	SO ₄ ²⁻ мг/л	19.3	500.0
Нитритийн ион /MNS 6779:2019/	NO ₂ мг/л	0.002	1.0
Нитратын ион /MNS 6834:2020/	NO ₃ мг/л	2.26	50.0
Фосфатын ион /MNS ISO 6878:2001/	PO ₄ ³⁻ мг/л	0.002	3.5
Фтор /MNS 6272:2011/	F ⁻ мг/л	1.61	0.7-1.5
Хатуулаг / MNS ISO 1097:1970/	Хатуулаг мг-эв/л	2.70	7.0
Натри Кали	Na+K мг/л	71.95	-
Цахилгаан дамжуулах чанар /MNS ISO 7888:1999/	EC µS/cm ³	586	1000
Гидрокарбонат MNS 6832:2020	HCO ₃ мг/л	298.9	-
Эрдэсжилт MNS ISO 1097:1970	мг/л	448.9	-
Орчин MNS ISO 10523:2001	pH	7.51	6.5-8.5

ХЯНАЖ БАТАЛГААЖУУНСАН
БОШЛ-Н ЭРХЛЭГЧ ИНЖЕНЕР: /Б.ГАНГАНБАЙГАЛ /
ШИНЖИЛГЭЭ ТҮЙЦЭТГЭСЭН
БОШЛ-Н ИНЖЕНЕР: /Б.ШҮРЭНЧИМЭГ /
Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.

Сорьцын дугаар: 44
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: “Чинг хөн вэй өз” ХХК шүүрлийн ус
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-н инженер Б.Шүрэнчимэг
Сорьцын тоо, хэмжээ: 1,5литр
Сорьцын төрөл: Ус
Сорьц авсан огноо: 2024-08.28
Лабораторид хүлээж авсан : 2024-08-30
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024-08-30
Хэвлэсэн огноо: 2024-10-14
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Тодорхойлсон үзүүлэлт Шинжилгээний арга стандарт	Сорьц авсан цэг “ Чинг хөн вэй өз” ХХК /шүүрлийн ус /	Хүлцэх агууламж мг/л	
		Хүлцэх агууламж мг/л	Хүлцэх агууламж мг/л
Жинлэгдэх бодис /MNS 6836:2020/	Ж/Б мг/л	28.4	-
Перманганатын исэлдэх чанар /MNS 6833:2020/	Пич мг/л	1.58	-
Кальцийн ион /MNS ISO 1097:1970/	Ca ²⁺ мг/л	44.0	-
Магний ион /MNS ISO 1097:1970/	Mg ²⁺ мг/л	2.34	-
Аммоний ион /CA3 1:2020/	NH ₄ ⁺ мг/л	2.06	-
Нийт төмөр /MNS 4430:2005/	Fe мг/л	0.05	-
Хлорийн ион /MNS 4424:2005/	Cl ⁻ мг/л	0.10	-
Сульфатын ион /MNS 6271:2011/	SO ₄ ²⁻ мг/л	23.7	-
Нитритийн ион /MNS 6779:2019/	NO ₂ мг/л	0.016	-
Нитратын ион /MNS 6834:2020/	NO ₃ мг/л	4.74	-
Фосфатын ион /MNS ISO 6878:2001/	PO ₄ ³⁻ мг/л	0.07	-
Фтор /MNS 6272:2011/	F ⁻ мг/л	1.54	-
Хатуулаг / MNS ISO 1097:1970/	Хатуулаг мг-эв/л	2.39	-
Натри Кали	Na+K мг/л	23.22	-
Цахилгаан дамжуулах чанар /MNS ISO 7888:1999/	EC µS/cm ³	328	-
Гидрокарбонат MNS 6832:2020	HCO ₃ мг/л	165.9	-
Эрдэсжилт MNS ISO 1097:1970	мг/л	262.8	-
Орчин MNS ISO 10523:2001	pH	7.45	-

ХЯНАЖ БАТАЛГААЖУУНСАН
БОШЛ-Н ЭРХЛЭГЧ ИНЖЕНЕР: /Б.ГАНГАНБАЙГАЛ /
ШИНЖИЛГЭЭ ТҮЙЦЭТГЭСЭН
БОШЛ-Н ИНЖЕНЕР: /Б.ШҮРЭНЧИМЭГ /
Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НИЙТ ТӨСӨВ

Д/д	Зардлын ангилал	Зардал, мян.төг
1.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	800,000
2.	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	5,906,305
3.	Нөхөн сэргээлт	-
4.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	18,156,000
5.	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ	-
6.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
7.	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1,100,000
8.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,800,000
9.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,122,500
	Нийт	28,884,805

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Сэрвэн” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол орны гуурст ургамлын тархалтын өнөөгийн төлөв байдал. М.Ургамал, Ж.Магсар, 2017 он.
2. Хэнтий аймгийн Батноров сумын сэрвэн ордын 2024 оны уулын ажлын төлөвлөгөө
3. ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “СЭРВЭН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
4. https://wwfasia.awsassets.panda.org/downloads/16p03_kherlen_goliin_sav_gazar_ud_egdeh.pdf
5. <https://www.adb.org/sites/default/files/institutional-document/324101/tool-kit-solid-waste-management-mn.pdf>
6. <https://legalinfo.mn/>

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Тусгай зөвшөөрлийн хуулбар
3. Улсын эрүүл ахуйн байцаагчийн дүгнэлт
4. Хог хаягдлын гэрээ
5. Ус ашиглуулах дүгнэлт
6. Усны гэрээ
7. Хог, усны төлбөр төлсөн баримт
8. Техникийн түрээсийн гэрээ
9. Аюулгүй ажиллагааны дотоод журам
10. Сургалтын удирдамж
11. Эм тарианы зардал

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ

1 Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар		2017.05.30
V204 Хууль тооцол зөрчилгүй		
		
МОНГОЛ УЛС ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ 000133257		
